



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/95

Номгон

Аймгийн Онцгой комиссын гишүүдийг
сумдад хуваарилан, шаардлагатай техник
хэрэгслийг дайчлан ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/253, 2024 оны А/27 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2023 оны 04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зудын эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, хаваржилтын нөхцөл байдлыг хохирол багатай даван туулах зорилгоор Улсын хэмжээнд 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, ажлын тусгай горимоор ажиллаж байгаатай холбогдуулан сумдын Онцгой комиссын Шуурхай штабын үйл ажиллагаа, зудын гамшгийн хариу арга хэмжээг эрчимжүүлэх аймгийн Онцгой комиссын гишүүдийн хариуцан ажиллах сумдын хуваарийг нэгдүгээр, зудын гамшгийн голомтод дайчилгаагаар үүрэг гүйцэтгэх туулах чадвар сайтай суудлын болон ачаа тээврийн автомашины томилгоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Зудын гамшгийг хохирол багатай даван туулах, малчдын амьжиргааг дэмжих чиглэлээр Засгийн газар болон Улс, аймгийн Онцгой комиссоос хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулж, хэрэгжилтийг хангуулах, зудад нэрвэгдсэн малчдын нийгмийн асуудал, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, зорилтот бүлгийн иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, бусад аймаг болон өөрийн аймгийн сумдын нутаг дэвсгэрт отор нүүдэл хийж байгаа малчдад эрүүл мэнд, нийгмийн халамж зэрэг төрийн үйлчилгээг харьяалал харгалзахгүйгээр шуурхай хүргэх, цаг агаарын аюулт үзэгдэл, шар усны үерээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг багц мессежээр сум, багийн иргэдэд хүргэх, эрсдэлд өртөх айл өрхийн судалгааг нарийвчлан гаргуулах, Засгийн газрын шийдвэрээр олгогдож буй өвс,

824010147


2.

тэжээлийг хариуцсан сум, багт хуваарийн дагуу малчин өрхөд хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах, мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, үзлэг тандалт судалгааг эрчимжүүлж, сумдыг мэдээ, мэдээллээр хангах, төв суурин газрын дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагын түлш, цахилгааны эх үүсвэрийн нөөцийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, өөрийн байгууллагын техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдал, (томилолтоор ажиллаж буй алба хаагчдыг дулаан хувцас, хоол хүнс, шатахуунаар бүрэн хангах) хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг чанд сахулж, Улсын болон аймгийн Онцгой комиссын Шуурхай штабаас авч буй тайлан, мэдээ, судалгаанд хяналт тавин шуурхай гаргуулах, тухайн сумдын төрийн алба хаагч, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг зудад нэрвэгдсэн малчиддаа туслах халуун сэтгэлийн хандивын аянд нэгдэхийг уриалах, хариуцсан сум дээр очиж ажилласан тохиолдолд илтгэх хуудас, фото тайланг албажуулан тухай бүр аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын bhrshtab@gmail.com цахим хаягаар хүргүүлж авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар аймгийн Онцгой комиссын дарга, Онцгой комиссын орлогч дарга нар болон шуурхай штабын 70440119 дугаарт тухай бүр холбоонд орж мэдээ, мэдээллээр ханган, нэгдсэн зохион байгуулалттай ажиллахыг аймгийн Онцгой комиссын сумд хариуцсан гишүүд болон нийт гишүүдэд;

3.Зудын гамшгийг хохирол багатай даван туулах зорилгоор хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахтай холбогдсон аливаа судалгаа, мэдээ мэдээллийг аймгийн Онцгой комисс болон шуурхай штабт заасан хугацаанд шуурхай гарган өгч, мэргэжлийн байгууллагыг судалгаа, мэдээллээр хангаж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын гамшгийн үеийн удирдлага, зохицуулалт хариуцсан орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН


Аймгийн Засаг даргын 2017 оны 17 дугаар сарын
 24 ны өдрийн 17 дугаар захирамжийн нэгдүгээр



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ГИШҮҮДИЙН
 ХАРИУЦАН АЖИЛЛАХ СУМДЫН ХУВААРЬ

Д/д	Онцгой комиссын гишүүд	Утасны дугаар	Хариуцан ажиллах сум
1	Г.Энхбаяр	88111709	Баянхонгор
2	Б.Батсуурь	88117865	Баацагаан
3	М.Мөнхбат	99442055	Баянбулаг
4	Н.Мэндбаяр	99889266	Баянговь
5	П.Наранбаатар	89039063	Баянлиг
6	Д.Дэлгэрдалай	88245399	Баян-Овоо
7	Ч.Оюунчимэг	99084803	Баян-Өндөр
8	Д.Энхжаргал	89110118	Баянцагаан
9	Э.Ганзориг	80808898	Богд
10	В.Наранчимэг	99029812	Бөмбөгөр
11	Хишигбаатар	88112834	Бууцагаан
12	Ц.Батхүү	88014961	Галуут
13	Д.Сарангарав	88083504	Гурванбулаг
14	Б.Мөнхбаяр	99004291	Жаргалант
15	Э.Энхтөр	89985454	Жинст
16	С.Амармөнх	88077606	Заг
17	П.Отгонбаяр	88062336	Өлзийт
18	Р.Мэндбаяр	99995007	Хүрээмарал
19	М.Мөнгөнцэцэг	99058522	Шинэжинст
20	Н.Энхжаргал	99442181	Эрдэнэцогт

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын
22-ны өдрийн 179 дугаар захирамжийн хөрөндүгээр
хавсралт



ЗУДЫН ГАМШГИЙН ГОЛОМТОД АЖИЛЛАХ ТУУЛАХ
ЧАДВАР САЙТАЙ АЧАА, ТЭЭВИЙН АВТОМАШИНЫ
ТОМИЛГОО

Д/д	Хариуцах байгууллага	Автомашины марк	Автомашины улсын дугаар	Автомашины жолоочийн овог нэр	Хуваарилагдсан сум
1	Зэвсэгт хүчний 339 дүгээр анги	Урал -375	Г693-051	а/а М.Жанболат 89968666	Гурванбулаг сум
2		ЗИЛ-131	19-50ЦАБ	а/а С.Гантөмөр 88292344	Баянбулаг сум
3		ЗИЛ-131	19-51ЦАБ	а/а Б.Наранбаатар 88283094	Заг, Байдраг сум
4		ГАЗ-66	19-48ЦАБ	а/а Ж.Ганзориг 89088668	Галуут сум
5		ГАЗ-66	19-49ЦАБ	Г.Амараа 88999392	Богд, Өлзийт, Жинст сум
6	Онцгой байдлын газар	ЗИЛ-131	Дугаар аваагүй	а/ч Я.Удвал 92013223	Бууцагаан Хүрээмарал сум
7		ГАЗ-66	00-64БНН	а/а Н.Баттулга 88099945	Эрдэнэцогт

ЗУДЫН ГАМШГИЙН ГОЛОМТОД АЖИЛЛАХ ТУУЛАХ
ЧАДВАР САЙТАЙ СУУДЛЫН АВТОМАШИНЫ ТОМИЛГОО

Д/д	Байгууллага	Автомашины марк	Автомашины улсын дугаар	Автомашины жолоочийн овог нэр
1	Онцгой байдлын газар	toyota land cruiser-78	78-00БНН	а/а Г.Галбадрах 89185384
2	ЗХ-ний 339-р анги	toyota land cruiser-76	19-41ЦАБ	д/а н.Жамбалсанжид 88014961
3	Тагнуулын хэлтэс	toyota land cruiser-200	00-70 БНР	О.Одгийв 86916691
4	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Toyota land cruiser-76	10-55БНХ	н.Цэнд-Аюуш 88446436
5	Мал эмнэлгийн газар	Toyota land cruiser-76	63-76БНА	Ц.Доржпалам 88620762
6	Байгаль орчин аялал жуулчлалын газар	toyota land cruiser-76	85-88 БНН	Б.Жаргал 94997616
7	Газрын харилцаа Барилга хот байгуулалтын газар	toyota land cruiser-200	11-66БНА	Н.Мөнхбаатар 88444100
8	Бөөнцагаан Орог нуурын сав газар	Nissan patrol-62	00-84 БНР	Д.Цэндбаяр 88445778
9	Татварын газар	Toyota land cruiser-76	20-01 БНА	Ц.Лодонсамбуу 99444604
10	Чандмань- Баянхонгор ХХК	toyota land cruiser-76	24-80 БНА	С.Лхагвасүрэн 99442055
11	Баянхонгор-Эрчим хүч ХХК	toyota land cruiser-76	84-84 БНН	Х.Бат-Оргил 95118001